



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 02 өдөр

Дугаар 0/320

Хэрлэн сум

Хэнтий аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй  
иргэдийн холбоонд дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалт, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.2, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 02 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сэлэнгэ аймагт зохион байгуулагдах Пара-волейболын улсын аварга шалгаруулах тэмцээнд Хэнтий аймгийн Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн холбооны баг тамирчид оролцох зардалд 1,800,000 (нэг сая найман зуун мянга)\_ төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардагдах хөрөнгийг Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний “Төр-Иргэний нийгмийн байгууллагын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх” зардлаас санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга (Д.Өнөрцэцэг)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ